

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернэтийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерийг олон нийтийн сүлжээнээс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд интернэтийг зөвхөн албан ажлынхаа хүрээнд ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулан ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт даалгав.

2. Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР